

БАТЛАВ
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ОЙН ГАЗРЫН ДАРГА



**ДОРойтсон ОЙД ШИЛМҮҮСТ МОДНЫ БОРТОГОТОЙ СУУЛГАЦААР
ОЙЖУУЛАЛТ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР
/ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ/**

№	Нэр төрөл, үзүүлэлт	Шаардлага
1	Үндэслэл	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын даргын 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан “Ойжуулалт хөтөлбөрийн 2024 онд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх шинэчилсэн төлөвлөгөө”-д тусгагдсан доройтсон ойг нөхөн сэргээж шилмүүст модны тарьцаар ойжуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.
2	Ажлын хамрах хүрээ	Шилмүүст модны бортоготой тарьцаар ойжуулалт хийх ажил Ойжуулалт хийх талбайн байршлыг ажлын даалгаварт хавсаргав.
3	Гүйцэтгэх ажил	Шилмүүст модны бортоготой тарьцаар ойжуулалт хийх. Нэг жилийн хугацаанд арчлах, нөхөн тарилт хийх.
4	Төсөвт өртөг	900.000.000 төгрөг (Есөн зуун сая төгрөг)
5	Талбайн хэмжээ	100 га талбай
6	Техникийн шаардлага	Доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажлыг гүйцэтгэх байгууллага нь ойжуулалт, тарьц суулгац, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой стандартуудыг мөрдөж ажиллана.
7	Техникийн шаардлага	Доройтсон ойг нөхөн сэргээх, бортоготой тарьцаар ойжуулах, арчлах ажлыг гэрээгээр гүйцэтгэх байгууллага нь ойжуулалт, тарьц суулгацын стандартуудыг мөрдөж ажиллана.
8	Модны төрөл	Шилмүүст одны бортоготой тарьцаар (шинэс)
9	Хугацаа	Хаврын тарилт 2024.05.10 Намрын нөхөн тарилт 2024.09.27 Дараах жилийн арчилгаа, нөхөн тарилт 2025.05.10 Тендерийн баримт бичигт заагдсан үе шатны ажлын хуваарь болон, гүйцэтгэгчээс ирүүлсэн тодотгосон үе шатны ажлын хуваарьтай уялдан өөрчлөгдөж болно.
10	Ажлын хамрах хүрээ	Дараах ажилбаруудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд: Бэлтгэл ажил - Ойжуулалт хийх - Ойжуулсан талбайг хүлээлгэн өгөх - Зөрчил гологдол арилгах - Тайлан боловсруулах

		<ul style="list-style-type: none"> - Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх - Дараа жилийн арчилгаа хамгаалалт
11	Гүйцэтгэх ажлын агуулга, үе шатууд	<p style="text-align: center;">Бэлтгэл ажил:</p> <ul style="list-style-type: none"> • Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдыг дадлагажуулах; • Ойжуулалтын ажилд хэрэглэгдэх техник тоног төхөөрөмжүүдийн техник үйлчилгээг бүрэн хийн ажилд гарахад бэлэн болгох; • Ойжуулалтын ажлын технологийн карт, дараалал боловсруулан ажилчдад танилцуулах, мөрдөх /технологийн дарааллын загварыг хавсаргав/ • Ойжуулах талбайг сонгох тэмдэгжүүлэх /Талбай сонгох ажлыг Ойн газрын холбогдох мэргэжилтнүүд, аймаг, дүүргийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ойн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, сумын болон сум дундын ойн ангийн инженер техникийн ажилчидтай зөвшилцөн сонгох/; • Ойжуулах талбайг цэвэрлэх /унанги, гишүү цэвэрлэх/ • Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэн өгөх; • Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгөх; • Тарьцыг бойжуулах талбайгаас ухаж авах, тээвэрлэхэд бэлдэх; • Тээвэрлэх, суулгах үед үндэсний систем хатахаас хамгаалахарга хэмжээ авах; • Ойр орчмын иргэдэд мал бэлчээхийг хориглох талаар танилцуулга, уулзалт зохион байгуулах
12		<p>Ойжуулалт хийх.</p> <ul style="list-style-type: none"> • “Мод сөөгийн тарьц. Техникийн шаардлага” MNS 6139:2010 стандартад нийцсэн тарьц ойжуулалтын ажилд хэрэглэх • Ойжуулахаар сонгосон талбайд зонхилон ургаж буй шилмүүст модны тарьцаар ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ. • Хөрсийг 0.4 x 0.4 метр хэмжээтэй жижиг талбайгаар гараар боловсруулна. Эгнээ хооронд 4 метр байхаар утас татаж жижигт албайнуудыг 4 x 1 метрийн зайтайгаар жигд байрлуулан хөрсний өнгөн хэсгийг 5-10 см гүнтэйгээр өвөөлжин жоотуу болон бусад гар багажуудаар хуулж аван газрын доод талдэргүүлэн дээш харуулж тавина /Схем 1/.

		<ul style="list-style-type: none"> • Ойжуулалтын шигүүрэл: мод хоорондоо 1 метр, эгнээ хооронд 4 метр байхаар тооцон 1 га талбайд 2500 ширхэг тарьц байхаар тооцож тарилт хийх /Схем 2/ • Хөрсний чийг тохиромжтой хувиас доогуур тохиолдолд услагаа хийх • Хөрсийг 4-5 см-ийн гүнд зөөллөж, хөл газрын ургамлыг устгахын хамт усалгааны дараа хөрсний чийгийг алдагдуулахгүйн тулд шороогоор дарж тарьц суулгац суулгасан нүхийг өргөтгөх
--	--	---

13		<p style="text-align: center;">Ойжуулсан талбайг хүлээлгэн өгөх.</p> <ul style="list-style-type: none"> • Ойжуулсан талбайг Ойн газраас томилогдсон ажлын хэсэг, орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт тус тус актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна. Ойжуулалтын ажлын явцын хяналтыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Ойн газраас томилогдсон ажлын хэсэг, төслийн менежер, орон нутгаас томилогдсон ажлын хэсэг тус тус хийж гүйцэтгэнэ. Ойжуулсан талбайг тухай аймаг, суманд акт үйлдэн хүлээлгэн өгнө. Актыг 5 хувь үйлдэх бөгөөд Ойн газарт эх хувиар нь ирүүлнэ. Аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон ажлын хэсгийн гаргасан актыг үндэслэн тарьсан тарьц, суулгацын амьдралд 75.0 хувиас дээш байвал уг ажлын гүйцэтгэлийг хангалттай гэж үзэн хүлээн авна. Амьдралын хувийг тогтоохдоо Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 03 дугаар сарын 29 өдрийн А-96/71 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу жишиг талбай байгуулан тооллого явуулна. <table border="1" data-bbox="657 1411 1484 1796" style="width: 100%; border-collapse: collapse; text-align: center;"> <thead> <tr> <th data-bbox="657 1411 906 1594">Ойжуулсан талбай /га/</th> <th data-bbox="906 1411 1273 1594">Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь</th> <th data-bbox="1273 1411 1484 1594">Нэгж жишиг талбайн хэмжээ /м²/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="657 1594 906 1639">1-5</td> <td data-bbox="906 1594 1273 1639">5</td> <td data-bbox="1273 1594 1484 1639">200</td> </tr> <tr> <td data-bbox="657 1639 906 1684">6-10</td> <td data-bbox="906 1639 1273 1684">4</td> <td data-bbox="1273 1639 1484 1684">400</td> </tr> <tr> <td data-bbox="657 1684 906 1729">11-20</td> <td data-bbox="906 1684 1273 1729">3</td> <td data-bbox="1273 1684 1484 1729">400</td> </tr> <tr> <td data-bbox="657 1729 906 1796">21-ээс дээш</td> <td data-bbox="906 1729 1273 1796">2</td> <td data-bbox="1273 1729 1484 1796">400</td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> • Ойжуулалтын ажлыг хүлээн авахдаа гэрээний ерөнхий ба тусгай нөхцөлийн дагуу зөрчил, гологдлыг арилгасны дараа “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмаар батлагдсан актын дагуу хүлээн авна. Ажлыг 	Ойжуулсан талбай /га/	Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь	Нэгж жишиг талбайн хэмжээ /м ² /	1-5	5	200	6-10	4	400	11-20	3	400	21-ээс дээш	2	400
Ойжуулсан талбай /га/	Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь	Нэгж жишиг талбайн хэмжээ /м ² /															
1-5	5	200															
6-10	4	400															
11-20	3	400															
21-ээс дээш	2	400															

		<p>гүйцэтгэх хугацаанд тухайн аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги болон сум орон нутагтай хамтран ажиллана</p>
13		<p style="text-align: center;">Зөрчил, гологдол арилгах.</p> <ul style="list-style-type: none"> • Тарьсан тарьц нь 50-74,9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгч өөрийн зардлаар 90 хувь хүртэл нөхөн тарилт хийж, актаар хүлээлгэн өгнө. • Тарьсан тарьц нь 25-49,9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгчид урьдчилгаагаар олгосон норматив зардалд хүрэхүйц шаардлагатай нөхөн тарилтыг гүйцэтгэгчийн хөрөнгөөр хийлгэж дараа жилийн намар хүлээж авна. • Тарьсан тарьц нь 24,9 хувийн амьдралтай тоологдсон тохиолдолд уг ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзэж гүйцэтгэгчээр ойжуулалтын ажлын урьдчилгааг эргүүлэн төлүүлнэ.
14		<p style="text-align: center;">Тайлан боловсруулах.</p> <ul style="list-style-type: none"> • Ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайланг захиалагчид 3 хувь ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд <p>а/ “Ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайлан”;</p> <p>б/ 1:50000-ны масштабтай Ойжуулалтын ажил явуулсан талбайн зураг;</p> <p>в/ “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын ажил хүлээн авах ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт.</p> <p>а. “Ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайлан”-д: Ойжуулалтын ажлын үе шат тус бүрээр хийсэн ажлын гүйцэтгэл, ойжуулалтын ажлын технологийн дараалал, тарилтын схем, тарьц, суулгацын стандартын шаардлага хангасан байдал, ажил гүйцэтгэсэн хугацаа, ажиллах хүчин, ажлын өдөр тутмын гүйцэтгэл, тавьсан хяналт зэрэг мэдээллийг багтаана. Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, ойжуулсан талбайн ерөнхий байдлын зургийг тайланд хавсаргана.</p> <p>б. “Ойжуулалтын ажил явуулсан талбайн зураг”-т: Хэсэглэл, ялгарлын хил, дугаар, талбай, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн байрлалын солбицлын торлолд, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн зааварт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна.</p> <p>в. “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын ажил хүлээн авах</p>

		<p>ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт тайланд хавсаргана.</p> <p>Тайланг захиалагчийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайланд зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ. Зөрчил гологдлыг арилгасан тухай төслийн менежер мэдэгдэл гарган дахин даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно.</p> <p>Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р сарын 28- ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтын тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATOR) тусгагийг хэрэглэнэ.</p> <p>Ойжуулалтын ажлын тайлан болон зургийн shp.файлуудыг цахим хэлбэрээр /CD, DVD/ 1 хувь ирүүлнэ</p>
15		<p>Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх</p> <p>Ойжуулалтын ажлын тайланг Ойн газарт гурван хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарьт тусгасан болно. Тайланг нээлттэйгээр хэлэлцүүлнэ.</p>
16		<p>Дараа жилийн арчилгаа, хамгаалалт</p> <p>“Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу ойжуулсан талбайгаа 1 жилийн хугацаанд арчлан хамгаалж ургуулах бөгөөд энэ үзүүлэлтийг дараагийн ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулахад нэг шалгуур үзүүлэлт болгоно. Шаардлагатай үед нөхөн тарилт хийх, хашаа хамгаалалтыг сэргээх, усалгаа хийх, түймэр хөнөөлт шавжаас хамгаалах арга хэмжээ зохион байгуулах, хөл газрын ургамалтай тэмцэх, хөрс сийрүүлэх зэрэг арга хэмжээг гэрээ хүчинтэй хугацааны турш хийж гүйцэтгэнэ.</p>
17	Бусад тавигдах шаардлага	<p>Дараах шаардлага тавигдана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Ажлын гүйцэтгэхэд шаардлагатай нийт ажилчдын 50 хүртэл хувийг тухайн сум орон нутгийн иргэд, малчдын бүлэг, нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулан хамтран гүйцэтгэнэ. • Ойжуулалтын талбайд гарсан хог хаягдлыг цэвэрлэж, хогийн төвлөрсөн цэг рүү тээвэрлэх ажлыг зохион байгуулна. <p>Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх явцдаа ажлын е шат бүрийг захиалагчид фото зургаар баталгаажуулан ирүүлнэ. Үний дараа дараагийн үе шатны ажлыг эхэлнэ.</p>
18	Үр дүнг тайлагнах	Захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг үндэслэн гэрээгсунгах, цуцлах эрхтэй

Ажил гүйцэтгэх байршил /багцын мэдээлэл/

№	Багцын дугаар	Багцын нэр	Талбайн хэмжээ, га	1 га талбайд таригдах модны модны тоо	1 га талбайн зардлын норматив, төгрөгөөр	Нийт таригдах модны тоо	Төсөвт өртөг, төг	Талбайн байршил, координат	Талбайн байршил, ОЗБ-ын материал
1	Багц 1	Төв аймаг Батсүмбэр Сөгнөгөрийн гол Бугандайн зоо	50	1350	9.000.000	67.500.00	450.000.000.00	107 2' 0", 48 28' 30"	92-6, 15, 17
2	Багц 2	Төв аймаг Батсүмбэр Шатангийн ам нууртын эх	50	1350	9.000.000	67.500.00	450.000.000.00	107 0' 0", 48 27'45"	10-4

Хянасан:

Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга

Б.Ганзориг

Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хариуцсан ахлах мэргэжилтэн


Б.Өсөхбаяр

Боловсруулсан:


Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн Таримал ой, байгалийн сэргэн ургалт хариуцсан мэргэжилтэн

А.Булган

Төв аймгийн Батсүмбэр суманд бортоготой тарьцаар ойжуулалт хийх талбайн зураг (Сөгнөгөрийн гол Бугандай) 50 га



Төв аймгийн Батсүмбэр суманд бортоготой тарьцаар ойжуулалт хийх талбайн зураг (Шатангийн ам нуурын эх) 50 га



ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМАНД ОЙЖУУЛАЛТЫН АЖИЛ ХИЙХ ТАЛБАЙН ЗУРАГ

ТАНИХ ТЭМДЭГ

92 Хэсэглэл

14 Ялгарал

Ойжуулалт хийх талбай

Төв аймаг Батсүмбэр сум
Ойжуулалт хийх талбай
Шилмүүмст модны бортогтой тарьц
Хэсэглэл: 109
Ялгарал: 4
Талбайн хэмжээ: 50 га
Ойн түймэрт өртсөн 2014 онд өртсөн
Газрын нэр: Сөгнөгөрийн гол, Бугандай
Сумын төвөөс 30 - 33 км

